

Гавьяат тамирчин Д.Нармандахын нэрэмжит өсвөр үеийн олон улсын жүдо тэмцээнийг дэмжин ажиллалаа

ХУРГАТАЙ
ХАЙРХАН



2025 оны 9-р сарын 26–28-ны өдрүүдэд Эрдэнэт хотод зохион байгуулагдсан **“Гавьяат тамирчин Д. Нармандахын нэрэмжит өсвөр үеийн олон улсын жүдо тэмцээн”**-ийг “Хургатай Хайрхан” ХХК хоёр дахь жилдээ ивээн тэтгэн ажиллаа.

ХУРГАТАЙ ХАЙРХАН

Энэхүү тэмцээн нь өсвөр үеийн тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, олон улсын түвшинд өрсөлдөх сэтгэл зүй, туршлага олгох, Монгол Улсын жүдогийн халааг бэлтгэх чухал ач холбогдолтой тэмцээн болж өрнөлөө.



ХУРГАТАЙ ХАЙРХАН

“Өсвөрийн тамирчдад тэмцээний уур амьсгалыг мэдрүүлэх нь хамгийн чухал. Дэлхийн жүдо спорт өндөр түвшинд хүрсэн энэ үед зөвхөн дасгал сургуулилт биш, бодит тэмцээнд хүч үзэх замаар хурцлагдах хэрэгтэй. Энэ тэмцээн нь өсвөр насны тамирчдад анхны том сорилт болж, цаашдын замналд томоохон туршлага өгөх юм.”

Д.Наранмандах

Атланта-1996 олимпын хүрэл медальт, Монголын жүдогийн анхны Ази тивийн аварга, гавьяат тамирчин



ХУРГАТАЙ ХАЙРХАН

Тэмцээнийг гурван насны ангиллаар зохион байгуулсан бөгөөд ангилал тус бүрийн тэргүүн байр эзэлсэн багуудыг танилцуулж байна.

Бага нас - эрэгтэй:
1-р байр: Гүрү дожо
2-р байр: Цагаанбаатар академи
3-р байр: Сэлэнгэ аймаг

Бага нас - эмэгтэй:
1-р байр: Хүлэг дэвжээ
2-р байр: Виннер дожо
3-р байр: Цагаанбарс дэвжээ

Дунд нас - эрэгтэй:
1-р байр: Чандмань оргил
2-р байр: Сургалтын төв
3-р байр: Дархан уул аймаг

Дунд нас - эмэгтэй:
1-р байр: Цагаанбаатар академи
2-р байр: Төв аймаг
3-р байр: Хөвсгөл аймаг

Ахлах нас - эрэгтэй:
1-р байр: Цагаанбаатар академи
2-р байр: Хангарди клуб
3-р байр: Гүрү дожо

Ахлах нас - эмэгтэй:
1-р байр: Шинэ бадрах
2-р байр: Виннер
3-р байр: Булган аймаг



ХУРГАТАЙ ХАЙРХАН

Тэмцээний онцлох зүйлс:

- Монгол Улсын 10 аймаг болон олон улсын оролцоотой зуу гаруй өсвөрийн тамирчид хүч чадлаа сорилоо.
- Туршлагатай шүүгчид, дасгалжуулагчид хамтран ажиллаж, тамирчдын ур чадварыг бодит тэмцээнд үнэлэв.









ХУРГАТАЙ ХАЙРХАН

Байгальд ээлтэй
Орон нутагт өгөөжтэй



Зураг. Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сум, 2024 он
“Хургатай Хайрхан” ХХК-ийн хэрэгжүүлдэг “Малын ногоон тэжээл” хөтөлбөрийн тариалангийн талбай